



Хураангуй зөвлөмж

- Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх үйлчилгээний үндэсний тогтолцоог ХХААХҮЯ-ны нэгдсэн зохицуулалт дор, бусад оролцогч талуудын хамтын ажиллагааг хангасан хэлбэрээр бий болгох замаар тус салбарын мэдлэг, инновацид суурилсан тогтвортой хөгжлийг хангах боломжтой.
- Уг тогтолцоонд ХААҮШУОНТ, аймгуудын ХХААГ, сумдын ЗДТГ зохицуулах ба хэрэгжүүлэх хавсарсан үүрэг хүлээж, орон нутагт нэвтрүүлэх үйлчилгээний үйл ажиллагааг багийн засаг дарга нар, жишиг аж ахуйнууд, зөвлөх малчид, зөвлөх тариаланчид гүйцэтгэнэ.
- Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх үйлчилгээний үндэсний тогтолцоог хуулчлах замаар тогтвортой байдлыг нь баталгаажуулж, холбогдох гэрээ хэлэлцээрүүдээр санхүүжилтийн олон эх үүсвэрийг бий болгох шаардлагатай.
- Нэвтрүүлэх үйлчилгээний хамрах үндсэн чиглэлүүдэд инновацийн зүүчлал, ХАА-н үйлдвэрлэгчдийн сургалт ба мэдээлэл, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа багтана.

ХХААХҮЯ-ны нэгдсэн зохицуулалт бүхий ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний үндэсний тогтолцооны загвар

Хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн бодлогод инновацид суурилсан үйлдвэрлэл, мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлэх зорилт чухал байр суурь эзэлдэг. Уг зорилтыг биелүүлэхийн тулд шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжуулах үйл ажиллагаа, зөвлөх үйлчилгээг тогтолцооных нь төвшинд бэхжүүлэх, уг тогтолцооны үлс, орон нутгийн төвшний оролцогч талуудын эрх үүрэг, хоорондын харилцааг зохицуулах бодлого, эрх зүй, институцийн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 188 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” (ХААҮШУОНТ)-ийг улсын төсөвт үйлдвэрийн газрын статустайгаар сэргээн байгуулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А-209 тоот тушаалаар аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газар (ХХААГ)-т нэвтрүүлэх үйлчилгээний ажил үүргийг хавсран хариуцсан орон тоо бий болгосноор ХАА-н салбарт нэвтрүүлэх үйлчилгээний нэгдсэн тогтолцоо бий болгох суурь бүрэлдээд байна. Түүнчлэн ХХААХҮЯ-наас “Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээний тухай хууль”-ийн төслийг боловсруулж, 2020 онд багтаан УИХ-д өргөн мэдүүлэхээр төлөвлөжээ.

ХХААХҮЯ-ны нэгдсэн зохицуулалт бүхий нэвтрүүлэх үйлчилгээний үндэсний тогтолцоог бий болгох бодлогын зорилтод нийцүүлэн тус тогтолцооны удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, нэвтрүүлэх үйлчилгээний үндсэн чиглэл, аргачлалуудын нэгдсэн загварыг цаашдын хэлэлцүүлэгт зориулан төсөл хэлбэрээр боловсруулсныг энэхүү бодлогын зөвлөмжид толилцуулж байна.



Нэвтрүүлэх үйлчилгээний үндсэн чиглэлүүд, хамрах үйл ажиллагаа

Нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн тодорхойлсон нэвтрүүлэх үйлчилгээний дараахь үндсэн чиглэлүүд ХХААХҮЯ-ны нэгдсэн зохицуулалтад хамаарна. Үүнд:

- Инновацийн зуучлал,
- ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдийн сургалт болон
- Мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ багтана.

ХАА-ын нэвтрүүлэх үйлчилгээний хамрах үйл ажиллагааг чиглэл тус бүрээр дараах хэсэгт товч тайлбарлав. Гэхдээ зарим үйл ажиллагаа нь дээрх чиглэлүүдэд бүгдэд нь нэгэн зэрэг чиглэдэг (жишээ нь талбайн сургалтыг сургалт, технологи дамжуулалт, мэдээлэл сурталчилгааны хавсарсан шинж чанартайгаар зохион байгуулдаг) болохыг анхаарна уу.

Инновацийн зуучлал нь технологи дамжуулалт (эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх) ба ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдийн инновацийн санаачлагыг дэмжих, сурталчлах гэсэн хоёр зорилгод чиглэнэ. Инновацийн зуучлалын үндсэн үйл ажиллагаа нь үйлдвэрлэлийн нөхцөлд туршилт судалгаа гүйцэтгэх, талбайн өдөрлөг, үзүүлэх сургалт, танилцах аялал, түршлага солилцох уулзалт ба мэргэжлийн зөвлөх үйлчилгээг хамрах ба хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулах мэдээлэл, сурталчилгааны ажлыг туслах үүрэгтэйд тооцно.

Үйлдвэрлэл эрхлэгчдийн сургалт өнөөг хүртэл зөвхөн албан бус хэлбэрээр явагдаж ирсэн бол цаашид албан ба албан бус гэсэн ялгаатай төвшинд зохион байгуулах шаардлагатай. Албан бус сургалтыг уламжлалт шавь сургалт (залуу малчид, тариаланчид нутгийн түршлагатай малчид, тариаланчдын аж ахуйд нь буюу гэрт нь очиж суралцах), талбайн сургалт гэсэн хоёр хэлбэрээр зохион байгуулж, талбайн сургалтад НҮБ-ийн ХХААБ-наас санаачлан, 90 гаруй оронд амжилттай нэвтрүүлсэн “Фермерийн талбайн сургууль”-ийн аргачлалыг мөрдөх нь тохиромжтой. Албан бус сургалт практик нөхцөлд, тухайн орон нутгийн онцлогт тохирсон хэлбэрээр хэрэгжих тул сургагч багшийн үүргийг судлаач, мэргэжилтнүүдэд бус, нутгийн түршлагатай малчид, тариаланчдад ногдуулах, үүний тулд сүм бүрт тодорхой шалгуурыг хангасан цөөн тооны малчид, тариаланчдад “зөвлөх малчин”, “зөвлөх тариаланч”-ийн статус олгох нь зүйтэй.

1990 оноос хойш ХАА-н салбарт гарсан нэг томоохон өөрчлөлт бол мэргэжлийн бус хүмүүс олноор тус салбарт өрхийн үйлдвэрлэл эрхлэх болсон явдал юм. ХАА-н салбарт, ялангуяа өрхийн аж ахуй дахь мэргэжлийн боловсон хүчний дутагдлыг нөхөх чиглэлээр одоог хүртэл дорвитой алхам хийгдээгүй. Түүнчлэн ХААИС, МСҮТ-үүдэд мал зүйч, агрономчийн мэргэжлээр суралцагчдын тоо цөөрөх, төгсөгчид ХАА-н үйлдвэрлэлд бус, өөр салбарт шилжин ажиллах зэрэг сөрөг үзэгдлүүд ажиглагдаж байгаагаас гадна үйлдвэрлэлд ажиллаж буй 30-аас дээш насныхан ХААИС буюу МСҮТ-д 2-4 жил суралцах боломж, сонирхол бага зэрэг хүчин зүйлсийг тооцож үзвэл албан сургалтын уян хатан тогтолцоог нэмж бий болгох бодит хэрэгцээ орон нутагт нилээд байгаа нь харагдаж байна. Иймд уг хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн ХХААХҮЯ-ны зохицуулалт бүхий нэвтрүүлэх үйлчилгээний үндэсний тогтолцооны хүрээнд ХАА-н албан сургалтын дэд тогтолцоог бий болгох нь зүйтэй. Бидний боловсруулсан загварын дагуу албан сургалтыг аймгийн ХХААГ-ууд хариуцаж, тухайн аймаг дахь дээд буюу мэргэжлийн боловсролын байгууллагатай хамтран зохион байгуулна. Багшлах боловсон хүчний хувьд ХААИС-ийн багш, судлаачид, эсхүл тодорхой шалгуураар магадлан итгэмжлэгдсэн орон нутгийн мэргэжилтнүүд ажиллах боломжтой. Сургалтыг модулиудад хуваан, тухайн орон нутгийн ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчийн ажлын ачаалал хамгийн багатай үеүдэд зохион байгуулах ба нэг модуль 2 долоо хоногос дээшгүй хугацаанд үргэлжилнэ. Сургалтыг кредит-цагаар хэмжих ба нийт хөтөлбөрөөс модуль бүрт ногдох кредит цагийг шалгалтын дүнгээс хамааруулан суралцагчдад олгож,



нийт кредит-цаг нь тодорхой босгод хүрсэн оролцогчдод гэрчилгээ олгоно. Уг гэрчилгээг авснаар суралцагдад бий болох давуу эрхүүдийг ХХААХҮЯ-наас холбогдох журмаар тодорхойлох нь зүйтэй. Дараахь давуу эрхийг санал болгож байна:

- “Сүм Хөгжүүлэх Сан”-д хөнгөлөлттэй зээлийн хүсэлт гаргах давуу эрх,
- “Зөвлөх малчин” буюу “зөвлөх тариаланч”-ийн статус авах, уг статусынхаа хүрээнд нэвтрүүлэх үйлчилгээний нэгдсэн төсвөөс бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлэх талбайн сургалт, шавь сургалтад багшлах;
- Цаашид ХААИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэн суралцах тохиолдолд албан сургалтаас авсан кредит-цагаа тооцуулж, түргэвчлэн суралцах.


Мэдээлэл, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг мэргэшсэн зөвлөх үйлчилгээ, нийт ХАА-н үйлдвэрлэгчдэд чиглэсэн үйл ажиллагаа гэсэн хоёр төвшинд ялгаж авч үзэх шаардлагатай. Голчлон томоохон фермерийн буюу тариалангийн аж ахуйнуудад чиглэдэг мэргэшсэн зөвлөх үйлчилгээг мэргэжлийн байгууллагууд, зөвлөх үйлчилгээний компаниуд, хараат бус зөвлөхүүд зэрэг ХХААХҮЯ-ны зохицуулалтад үл хамаарах этгээдүүд хариуцах тул үүнд яамны оролцоо шаардлагагүй. Харин ХХААХҮЯ-ны зохицуулалттай нэвтрүүлэх үйлчилгээ нь нийт малчид, тариаланчдад мэдээлэл, зөвлөгөө өгөх чиглэсэн уулзалт, өдөрлөг, явуулын номын сан буюу “мэдээллийн богц” аялуулах, олон нийтийн хэвлэл мэдээллийн ба цахим хэрэгслүүдээр мэдээлэл, зөвлөмж түгээх зэрэг үйл ажиллагааг хамарна.

Нэвтрүүлэх үйлчилгээний үндэсний тогтолцооны бүтэц, оролцогч талуудын эрх, үүрэг

ХААУШУОНТ нь ХХААХҮЯ-ыг төлөөлөн, ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний үндэсний тогтолцооны зохицуулагчийн статустайгаар ажиллаж, аймгуудын ХХААГ-ын нэвтрүүлэх үйлчилгээний жилийн ажлын төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт, үнэлгээ хийх эрх, үүргийг хүлээнэ. Түүнчлэн аймгуудын сургагч багш нарыг сургаж бэлтгэх, албан ба албан бус сургалтын хөтөлбөр, материал, гарын авлага боловсруулж ХХААГ-уудад хүргүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сургалт, сурталчилгааны цуврал нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж цацах зэрэг ажлыг хариуцахаас гадна гадны санхүүжилттэй төсөл, гэрээт ажлуудыг өөрөө гүйцэтгэх буюу ХХААГ-уудад зуучлан гүйцэтгүүлж болно.

ХХААГ-ууд сумдын ЗДТГ-уудыг нэвтрүүлэх үйлчилгээний ерөнхий зохицуулалт, удирдамж, мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалаар хангахаас гадна ХАА-н үйлдвэрлэгчдийн албан сургалт, зөвлөх малчид, тариаланчид, багийн засаг дарга нарын албан бус сургалт, орон нутгийн жишиг аж ахуйнуудад төлөвлөгдсөн нэвтрүүлэх үйлчилгээний үйл ажиллагааг удирдан, зохион байгуулна.

Сумын ЗДТГ тухайн сумын зөвлөх малчид, зөвлөх тариаланчид, багийн засаг дарга нарын хэрэгжүүлэх нэвтрүүлэх үйлчилгээний үйл ажиллагааг төлөвлөж, зохицуулна. **Зөвлөх малчид, зөвлөх тариаланчид** талбайн сургалт ба шавь сургалт зохион байгуулах, багийн засаг дарга нар сумаас хангаж өгсөн мэдээлэл, материалыг ашиглан малчид, тариаланчдад явуулын номын сангийн үйлчилгээ үзүүлэх буюу “мэдээллийн богц” аялуулах, түршлага солилцох уулзалт, арга хэмжээнүүдийг баг, бүлэг, хот айлын төвшинд зохион байгуулах ажлыг тус тус хариуцна.



ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний үндэсний тогтолцооны бүтэц, үйл ажиллагаа

Жишиг аж ахуйнууд нь тодорхой шалгуураар орон нутгийн малчин өрх, фермерийн буюу тариалангийн аж ахуйнуудаас сонгогдон шалгарсан, инновацийн зуучлалын үйл ажиллагаа (үйлдвэрлэлийн нөхцөл дэх туршилт судалгаа, талбайн өдөрлөг, үзүүлэх сургалт, туршлага хуваалцах бусад арга хэмжээ зохион байгуулах, сурталчилгааны материал бэлтгэх, нийгмийн сүлжээгээр видео сурвалжлагаа шууд цацах г.м.) эрхлэх эрх, үүрэгтэй аж ахуйнууд байх бөгөөд уг үйл ажиллагаанд нэвтрүүлэх үйлчилгээний нэгдсэн төсвөөс зарцуулах боломжтой байх шаардлагатай.


ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний үндэсний тогтолцоонд жишиг аж ахуйнууд чухал үүрэгтэй болохыг олон өнцгөөс тайлбарлаж болох бөгөөд үүнээс зөвхөн хоёр үндэслэлийг сонгон авч үзье. Нэгдүгээрт, шинээр бий болсон технологи, аргачлалуудыг жишиг аж ахуйнуудад турших ажлыг тогтмолжуулснаар эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн уялдаа бодитоор бэхжиж, туршиж буй технологи, аргачлалын практик ач холбогдол, үр дүнг нутгийн ХАА-н нийт үйлдвэрлэгчид үйлдвэрлэлийн бодит нөхцөлд үнэлж дүгнэх боломжтой болно. Нөгөө талаар жишиг аж ахуйнууд эрдэм шинжилгээний байгууллагуудаас бий болгосон технологиудыг туршиж, сурталчлахаас гадна өөрсдөө шинэ технологи буюу бүтээгдэхүүн хөгжүүлж, турших, сурталчлах идэвх санаачлага нэмэгдэх ба үүнээс улбаалж нийт ХАА-н үйлдвэрлэгчдэд инновацийн сэтгэлгээ төлөвших хандлага үүснэ. Ингэснээр инновацид суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудал зөвхөн технологи дамжуулалтаар хязгаарлагдахаа больж, үйлдвэрлэлийн төвшинд инновацийн орчин бодитоор бүрдэх юм. Өргөн уудам нутагт тархан байрласан манай орны ХАА-н үйлдвэрлэгчдэд эрдэм шинжилгээний байгууллагууд тэр бүр хүрч ажиллах хүчин чадал хүрэлцэхгүй тул үйлдвэрлэл эрхлэгчдийн инновацийн санаачлагыг дэмжих нь чухал ач холбогдолтой.



Нэвтрүүлэх үйлчилгээний санхүүжилт

ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний нэгдсэн төсөв нь ХХААХҮЯ-наас олгох улсын төсөв ба дараахь эх үүсвэрүүдээс авах нэмэлт санхүүжилтээс бүрдэнэ. Үүнд:

- ХАА-н судалгаа, хөгжүүлэлтийн ажлын улсын төсөв (БСШУЯ, ШУТС, ХААИС)
- Олон улсын төсөл, хөтөлбөрүүд;
- ХАА-н үйлдвэрлэгчдэд материал, тоног төхөөрөмж нийлүүлэгчид ба боловсруулах үйлдвэрүүд;
- ХАА-н үйлдвэрлэгчид.



Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх үйлчилгээний санхүүжилт

ХХААХҮЯ-наас жил бүр ХААШҮОНТ болон аймгуудын ХХААГ-уудад нэвтрүүлэх үйлчилгээний үйл ажиллагааны төсөв олгох ба ХХААГ-уудын төсвийн ихэнх нь сумдын ЗДТГ-аар дамжин жишиг аж ахуйнууд, багийн засаг дарга нар болон зөвлөх малчид, зөвлөх тариаланчдын хариуцан гүйцэтгэх үйл ажиллагаанд зарцуулагдана.

ХАА-н судалгаа, хөгжүүлэлтэд олгох улсын төсвийн тодорхой хувийг ХААШҮОНТ болон ХХААГ-уудаар дамжуулан технологи дамжуулалтын үйл ажиллагаанд, ялангуяа орон нутгийн жишиг аж ахуйнуудад түршилт судалгаа гүйцэтгэх, мэдээлэл, сурталчилгааны ажлууд зохион байгуулахад зарцуулах боломжтой. Эрдэм шинжилгээ, нэвтрүүлэх үйлчилгээний тогтолцоонуудын хоорондох энэхүү уялдааг ХХААХҮЯ-наас БСШУЯ болон ХААИС-тай хамтын ажиллагааны үрт хугацааны гэрээ байгуулах замаар бүрдүүлж болно.

Хөгжлийн хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн нилээд хувь нь нэвтрүүлэх үйлчилгээний үйл ажиллагаанд зарцуулагддаг боловч үүнд ХААШҮОНТ, аймгийн ХХААГ-уудын



оролцоо маш бага байдаг. Иймд ХХААХҮЯ-наас хандивлагч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээндээ нэвтрүүлэх үйлчилгээний ажил үүргийг ХАА-ын нэвтрүүлэх үйлчилгээний үндэсний тогтолцооны гол оролцогчид болох ХААҮШУОНТ болон аймгуудын ХХААГ-уудад хариуцуулах, хамтран ажиллах талаар заалт, зөвлөмж оруулах нь зүйтэй.

ХАА-н үйлдвэрлэгчдэд материал, тоног төхөөрөмж нийлүүлэгчид болон боловсруулах үйлдвэрүүд сургалт, сурталчилгаа, мэдээлэл, зөвлөх үйлчилгээнд нэгэнт тодорхой төсөв зарцуулдаг жишиг хэдийнэ тогтсон тул уг төсвийн тодорхой хэсгийг гэрээт ажлын хэлбэрээр ХАА-ын нэвтрүүлэх үйлчилгээний үндэсний тогтолцоонд чиглүүлэх боломжтой. Үүний тулд үндэсний тогтолцоо нь хувийн хэвшлийн ААН-үүдийн зүгээс үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнд тавих шаардлагад нийцсэн байх шаардлагатай.

ХАА-н үйлдвэрлэгчид нэвтрүүлэх үйлчилгээний дараахь үйл ажиллагаанд төлбөр төлж хамрагдана.

Үүнд:

- ХХААГ-аас зохион байгуулах албан сургалтын төлбөрийг бүрэн төлөх;
- Шавь сургалтад хамрагдахдаа тодорхой хэмжээний төлбөр төлөх. Суралцагчийн төлөх төлбөрийн хэмжээг нэгдсэн тарифаар тогтоох бөгөөд хэрэв суралцагч сургагч багшийн аж ахуйд үйлдвэрлэлийн дадлага хийх буюу туслах ажилчнаар ажиллах бол цалинг нь төлбөрөөс суутгаж болно.
- ХААҮШУОНТ, ХХААГ, жишиг аж ахуйнууд, зөвлөх малчид буюу зөвлөх тариаланчдаас тусгайлсан, нэмэлт зардалтай мэдээлэл, зөвлөгөө өгөх буюу зүүчлалын үйлчилгээ авах хүсэлтэй бол төлбөрийг нь бүрэн буюу хэсэгчлэн төлнө.

Бодлогын зөвлөмж

1. Нэвтрүүлэх үйлчилгээний төсвийн баталгаат байдлыг хангах

- ХХААХҮЯ-ны нэгдсэн зохицуулалт бүхий ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний үндэсний тогтолцоонд улсын төсвөөс тогтмол санхүүжилт олгох асуудлыг хуульчлах;
- ХАА-н судалгаа, хөгжүүлэлтэд олгох улсын төсөв ба хөгжлийн хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрийн төсвөөс нэвтрүүлэх үйлчилгээний ажил үүрэгт ногдох тодорхой хувийг ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний нэгдсэн төсөвт шилжүүлэх талаар ХХААХҮЯ-ны зүгээс холбогдох талуудтай гэрээ хэлэлцээр байгуулах;
- ХААҮШУОНТ болон аймгуудын ХХААГ-уудын сургалтын материаллаг баазыг сайжруулах, цахим сургалтын иж бүрэн тоноглол суурилуулахад хөрөнгө оруулах.

2. Нэвтрүүлэх үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх

- ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний үндэсний тогтолцооны бүтэц, тус тогтолцооны гол оролцогчид болох ХААҮШУОНТ, ХХААГ, сумын ЗДТГ-ын эрх, үүргийг хуульчлах.
- Орон нутгийн ХАА-н үйлдвэрлэгчдэд тогтмол мэдээлэл түгээх, туршлага солилцох уулзалт, өдөрлөг, бусад арга хэмжээг улирал бүр зохион байгуулах үүргийг багийн засаг даргын “Ажлын байрны тодорхойлолт”-од нэмж оруулах.
- ХАА-н үйлдвэрлэгчдийн албан сургалтыг модульт сургалтын хэлбэрээр, кредит-цагийн үнэлгээтэйгээр тухайн аймаг дахь дээд буюу мэргэжлийн боловсролын байгууллагатай хамтран зохион байгуулах эрх, үүргийг ХХААГ-уудад ногдуулах, мөн сургалтыг дүүргэсэн тохиолдолд олгох гэрчилгээ суралцагчдад бий болгох давуу эрхүүдийг холбогдох журмаар баталгаажуулах (жишээ нь ХААИС-д бакалаврын хөтөлбөрөөр түргэвчлэн суралцах г.м.).
- ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний үндэсний тогтолцооны бүтцэд багтах “жишиг аж ахуй”-н статусыг хуульчилж, шалгуур үзүүлэлтүүд, хүлээх эрх үүргүүд болон жишиг аж ахуйд



хэрэгжүүлэх зарим үйл ажиллагаанд нэвтрүүлэх үйлчилгээний нэгдсэн төсвөөс зарцуулах тухай журам боловсруулж, мөрдөх.

- ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний үндэсний тогтолцооны бүтцэд багтах “зөвлөх малчин” and “зөвлөх тариаланч”-ийн статусыг хуульчилж, шалгуур үзүүлэлтүүд, хүлээх эрх үүргүүд болон тэдгээрийн хэрэгжүүлэх нэвтрүүлэх үйлчилгээний үйл ажиллагаанд нэвтрүүлэх үйлчилгээний нэгдсэн төсвөөс зарцуулах тухай журам боловсруулж, мөрдөх.

Жишиг аж ахуйнууд болон “зөвлөх малчин”, “зөвлөх тариаланч”-идтай холбоотой харилцааг зохицуулах журмуудыг боловсруулахын тулд, тэдгээрийн тоо, төрлийг аймаг бүрээр тогтоох нарийвчилсан судалгаа гүйцэтгэх шаардлагатай.

Ашигласан хэвлэл

Монгол улсын Засгийн газар (2018). Монгол улсын Засгийн газрын тогтоол (дугаар 188) “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”. Эх сурвалж: www.legalinfo.mn/law/details/13579. Хамгийн сүүлд үзсэн огноо: 2020 оны 2-р сарын 10.

Хөдөө Аж Ахуйн Үйлдвэрлэлд Шинжлэх Ухааны Ололт Нэвтрүүлэх Төв (ХААҮШУОНТ) (2019). Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төвийн стратегийн төлөвлөгөө 2020-2024 (хэвлэгдээгүй).

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (2018). Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаал (дугаар А-209) (нийтлэгдээгүй).

Тайлбар: Энэхүү бодлогын зөвлөмжид багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийг санхүүжүүлэгч ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

Зохиогч

Б.Эрдэнэболор, PhD

Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн мэргэжилтэн

Имэйл: erdenebolor@iacleipzig.de